



**ГЛОБ
ИНТЕРНЭШНЛ
ТББ**



**Нээлттэй
Нийгэм
Форум**

Чингэлтэй дүүрэг. 6-р хороо. Дипломат 95 цогцолбор. 1-р орц. 6 тоот, Шуудангийн хаяг: 211238, Ш/Х №102, Zip code: 15170, утас: 324627, утас/ факс: 324764, e-mail: globe@maginet.mn, globe@globeinter.org.mn, вэб сайт: www.globeinter.org.mn, www.monitoring.mn

Сүхбаатар дүүрэг. Жамъян гүний гудамж-5/-1, Улаанбаатар-48, Монгол Улс Утас: (976-11) 313207, факс (976-11) 324857, Вэб: www.forum.mn.

2009 оны 9-р сарын 10-ний өдөр

Дугаар № 49/09

Улаанбаатар хот

Ерөнхийлөгчийн хүний эрх, иргэний оролцооны бодлогын зөвлөх Ц.Оюунгэрэл танаа

274 тоот албан бичгийн хариуд

Танаас 2009 оны 8 сарын 10-ны өдөр ирүүлсэн албан бичгээр хүний эрхэм байдал, эрх, эрх чөлөөг хамгаалах үүднээс хуулийн зарчим боловсруулсантай анхааралтай танилцлаа.

Хүний эрхийг дээдэлдэг ардчилсан нийгмийн хөгжлийг бэхжүүлэх чиглэлээр та бүхний гаргаж буй саналыг талархан хүлээн авч байна. Албан бичигт дурдсан зарчмын зарим нь Үндсэн Хуулийн 2-р бүлэг, Эрүүгийн хуулийн 25-р зүйлийг давтсан шинжтэй байна.

Хүний эрхэм чанарыг хамгаалах үүднээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүнийг амьдрал дээр бодитой хэрэгжүүлдэг хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлаж болохыг олон улсын хууль хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ хэвлэлийн эрх чөлөө бол хүний үндсэн эрхийн болон ардчиллын тулгуур зарчмын нэг билээ. Иймд хэвлэлийн эрх чөлөөг хуулиар хязгаарлахдаа туйлын болгоомжтой хандах ёстой. Учир нь хуулийн аливаа хязгаарлалт нь хэрэгжих явцдаа чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн эсрэг төрийн хатуу цензур болон хувирах нь хялбар байдаг. Төрийн цензур нь хуулийн хариуцлага, санкци, цагдаа, шүүхийн дарамт болон бусад олон зүйлээр илэрдэг. Тийм ч учраас олон улс орон Үндсэн хуулиараа цензурыг хориглосон байдаг билээ. Иймд албан бичигт дурдсан зарчмыг ямар хуульд, хэрхэн оруулах, эсвэл өөр аргаар зохицуулах эсэхийг сайтар тунгаан бодох ёстой юм.

Ер нь бол хүний эрхийг хүндэтгэх иймэрхүү зарчмыг хуулиар бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн ёс зүйн кодоод тусгаж, өөрийн зохицуулалтын тогтолцооны хүрээнд зохицуулдаг.

Албан бичигт мөн “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль”, “Хэвлэл мэдээллийн байгууллагын тухай хууль-ийн тухай дурдсан. Эдгээр хууль намрын чуулганы хэлэлцэх асуудалд орсоныг бид мэднэ. Хэрэв эдгээр зарчмыг Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд тусгахаар төлөвлөж буй бол энэ нь зохисгүй гэж бодож байна.


Хэвлэл мэдээллийн байгууллагын тухай хууль гэж байх нь бүр зохимжгүй. Харин олон оронд хэрэгжиж буй мэдээлэл үйлдвэрлэгч хэрэгслийнх нь хувьд үйл ажиллагааг нь зохицуулсан Өргөн нэвтрүүлгийн тухай хууль байж болно. Тэгвэл зарчмын заримыг ийм хуульд тусгаж болох юм. Учир нь, өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл нь ард түмний өмч болох долгион ашигладаг тул нэвтрүүлгийн агуулгад зарим хязгаарлалт тавихыг олон улсын жишгээр хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ ийм хуулийг судалгаагүйгээр яаравчлан гаргахгүй байхыг зөвлөө.

Ер нь цаашид сэтгүүлчид, ялангуяа хэвлэл мэдээллийн удирдлагын хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, нийгмийн хэлэлцүүлэг өрнүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимтэй, өргөнөөр зохион байгуулах нь эдгээр зарчмыг хүлээн зөвшөөрөх, зөвхөн сэтгүүлч бус цагдаа, шүүх, төрийн ажилтан гээд нийтээрээ хүний эрхийг дээдлэн хүндэтгэх соёл бий болгож хэвшүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулах болов уу.

Иймд үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн болон хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, эрх зүйн орчныг таатай болгох чиглэлээр мэргэшсэн манай байгууллагын энэхүү саналыг та бүхэн хүндэтгэн хүлээн авна гэдэгт итгэж байна.

Хүндэтгэн ёсолсон,

ННФ-ын Гүйцэтгэх захирал



П.Эрдэнэжаргал



Глоб Интернэшнл ТББ-ын
тэргүүн

Х.Наранжаргал

Хуулбарыг Олон
нийттэй харилцах бодлогын
Ерөнхийлөгчийн зөвлөх
А.Ганбаатарт